


ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: Энэ долоо хоногт АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд уналттай хаагдлаа. Зах зээлийн үнэлгээ өндөр компаниудын хувьцааны ханш зах зээлийн үнэлгээ бага компаниудтай харьцуулахад илүү өсөлттэй байв.

9-р сарын 14-ний өдөр Саудын Арабын газрын тосны томоохон байгууламж халдлагад өртөн, дэлхийн газрын тос олборлолтод ойролцоогоор 5%-ийн хохирол учрав. Үүнтэй холбоотойгоор Даваа гарагт газрын тосны үнэ 2016 оноос хойш хамгийн ихээр буюу 13%-аар өсжээ. Энэхүү өсөлтөөс хойш газрын тосны үнэ хэлбэлзэл ихтэй байсан ба Саудын Арабаас хохирлын хэмжээг тооцон, газрын тосны үйлдвэрлэл хэвийн явагдаж эхлэх хүртэл газрын тосны үнэ тогтворгүй байх хандлага ажиглагдаж байна. Хувьцааны зах зээлд энэхүү явдлаас үүдэн томоохон хөдөлгөөн үүсээгүй ч, зах зээлийн үнэлгээ харьцангуй багатай тээвэрлэлтийн салбарын компаниудын хувьцааны үнэ газрын тосны үнэ огцом нэмэгдсэнтэй холбоотойгоор уналт үзүүлээ.

9-р сарын 17, 18-ны өдрүүдэд зохион байгуулагдсан АНУ-ын Холбооны нөөцийн сангийн мөнгөний бодлогын хурлын шийдвэрээр бодлогын хүүг 0.25%-аар дахин бууруулахаар болжээ. Хөрөнгө оруулагчид энэхүү шийдвэрийг урьдчилан таамаглаж байсан учраас хөрөнгийн зах зээлд огцом савалгаа үүсээгүй байна. Цаашид Холбооны нөөцийн сан ямар арга хэмжээ авах нь тодорхойгүй байгаа ажээ.

Европ: Энэ долоо хоногт Европын хөрөнгийн зах зээлийн индексүүд хөдөлгөөн багатай байлаа. Европын бүсийн хөрөнгийн зах зээлийн STOXX Europe 600 индекс 0.4% өссөн бол Их Британи улсын FTSE 100 болон ХБНГУ-ын DAX индексүүд бага хэмжээгээр унасан байна.

Их Британи Европын холбооноос хэлэлцээртэй гарах магадлал нэмэгдсэнтэй холбоотойгоор фунтийн ханш ам.долларын эсрэг чангарсан ч, Английн Төв Банк богино хугацааны бодлогын хүүг бууруулах магадлалтай байгаа нь фунтийн ханшийг сулруулах юм. Шинжээчид Их Британи улсыг Европын холбооноос ямар нэг хэлэлцээргүй гарах магадлалыг 70%-тай байна хэмээн үзлээ.

Энэ долоо хоногт Английн төв банк бодлогын хүүгийн төвшинд өөрчлөлт оруулахгүй гэдгээ мэдэгджээ. Гэсэн хэдий ч "Брексит" хэлэлцээрийн тодорхойгүй байдлаас үүдэн Төв банк бодлогын хүүг доогуур барих ба тус улс Европын холбооноос хэлэлцээргүй гарах нь эдийн засагт сөргөөр нөлөөлөх аюултайг онцолжээ.

Япон: Япон улсын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй хаагдлаа. Японы төв банкны энэ сарын Мөнгөний бодлогын хурлаар богино хугацааны бодлогын хүүг -0.1%, 10 жилийн хугацаатай Засгийн газрын бондын зорилтот өгөөжийг 0% хэвээр үлдээхээр шийдвэрлэв. Японы төв банк Мөнгөний бодлогын мэдэгдэлдээ 2020 оны хавар хүртэл мөнгөний бодлогыг хэвээр үлдээх зорилготой байгаа ч зорилтот инфляцын төвшин 2%-д хүрэхгүй тохиолдолд мөнгөний зөөлөн бодлого баримтлах болно гэдгээ илэрхийлэв.

Япон улсын эрх баригчид эдийн засаг сэргэж байгаа ч, экспортын хэмжээ багасч байгааг мэдээллээ. Япон улсын экспортын төвшин 9 дэх сараа дараалан буурчээ.

БНХАУ: БНХАУ-ын эдийн засгийг голлох үзүүлэлтүүд хүлээлтээс доогуур төвшинд байсантай холбоотойгоор БНХАУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд уналттай байлаа.

8-р сард аж үйлдвэрлэлийн гарц 2002 оноос хойших хамгийн бага өсөлтийг үзүүлсэн бол жижиглэнгийн худалдааны борлуулалтын хэмжээ шинжээчдийн таамаглаж байснаас доогуур төвшинд байв. Баасан гарагт БНХАУ-ын Төв банк эдийн засгийг дэмжих зорилгоор нэг жилийн хугацаатай банкны зээлийн хүүг дахин буурууллаа.

Эх сурвалж: Troweprice.com

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	18,987.51	-2.52% ▼
Dow Jones	АНУ	26,935.07	-1.05% ▼
S&P 500	АНУ	2,992.07	-0.51% ▼
Nasdaq	АНУ	8,117.67	-0.72% ▼
S&P/TSX	Канад	16,899.69	1.30% ▲
FTSE 100	Их Британи	7,344.92	-0.31% ▼
S&P/ASX 200	Австрали	6,730.80	0.92% ▲
Nikkei 225	Япон	22,079.09	0.41% ▲
Hang Seng	Хонг Конг	26,435.67	-2.34% ▼

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	113.25
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	102.46
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	101.35
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	109.92
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	104.00
DBM' 2023	USD	7.250%	103.60
TDBM' 2020	USD	9.375%	102.63
MGMTGE' 2022 (Өүлэн)	USD	9.750%	99.20

Зах зээлийн хүү

ХҮҮ	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	2.037	0.01 ▲
Libor 3M	2.135	0.00 ▼
Libor 6M	2.070	0.00 ▲
Libor 1YR	2.065	0.02 ▲
US 2YR Bond	1.683	-0.12 ▼
US 3YR Bond	1.616	-0.14 ▼
US 5YR Bond	1.600	-0.15 ▼
US 10YR Bond	1.722	-0.17 ▼

Валютын ханш /төг/

Валют	2019.09.20	Өөрчлөлт
USD	2,667.91	-0.11% ▼
CNY	376.38	-0.24% ▼
EUR	2,948.31	-0.49% ▼
RUB	41.81	0.94% ▲
KRW	2.24	-1.32% ▼
JPY	24.72	-0.08% ▼
CAD	2,010.79	-0.46% ▼

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /спот/	USD/t oz.	1,516.90	0.80% ▲
Мөнгө /спот/	USD/t oz.	17.99	3.13% ▲
Зэс	USD/lb.	260.65	-3.45% ▼
Нүүрс	USD/MT	70.17	-0.43% ▼
WTI газрын тос	USD/bbl.	58.09	5.91% ▲
Brent газрын тос	USD/bbl.	64.28	6.74% ▲

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2019. VIII	8.90%
Бодлогын хүү	2019. VIII	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2019. VIII	11.26%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2019. VIII	11.42%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2019. VIII	4.99%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2019. VIII	16.94%
Зээлийн дундаж хүү /валют/	2019. VIII	10.75%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 42 компанийн 447.1 сая төгрөгийн 1,074,739 ширхэг хувьцаа арилжаалагдав.

“Сор” /SOR/ компанийн хувьцаа 14.76%-аар буюу хамгийн ихээр өсөж 1,135.0 төгрөгт хүрч хаагдсан бол “Монгол алт” /ERS/ компанийн хувьцаа 27.67%-аар буурч 6,510.0 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

9-р сарын 20-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,488.6 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 18,987.51 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 2.52%-аар буурсан байна.

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	447.1
Зах зээлийн үнэлгээ	2,488,601.5

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	18,987.51	-2.52% ▼
MSE I индекс	8,880.51	-1.19% ▼
MSE II индекс	7,454.85	-2.10% ▼

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
Ард санхүүгийн нэгдэл	158,726	221,526,348
Говь	345,347	97,945,343
АПУ	51,624	25,990,427
Таван толгой	2,431	15,870,645
Түмэн шувуут	83,185	13,396,284

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Сор	1,135.00	14.76% ▲
Дархан хөвөн	9,500.00	11.76% ▲
Ремикон	25.00	11.11% ▲
Хөх ган	70.00	10.24% ▲
Шивээ овоо	2,494.00	5.01% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Монгол алт	6,510.00	-27.67% ▼
Ариг гал	3,000.00	-14.29% ▼
Монгол шилтгээн	270.00	-13.18% ▼
Махимпекс	2,250.00	-12.35% ▼
Сүү	181.56	-8.18% ▼


Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Ард Секюритиз	471,184,931
БиДиСек	148,603,826
Голомт Капитал	64,757,697
Стандарт инвестмент	50,557,321
Бумбат-Алтай	29,544,099

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани


Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	504.12	536,475
Таван толгой	6,485.00	341,534
МИК Холдинг	13,700.00	283,718
Говь	284.01	221,560
Инвескор ББСБ	2,000.00	143,456

MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2019 он/



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

ЗГҮЦ-НЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-	-

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	Симбол	Компанийн нэр	2018 оны цэвэр ашиг /сая төг/	Нийт хуваарилах ногдол ашиг /сая төг/	Ногдол ашиг төлөлтийн харьцаа	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	HRM	Гермес центр ХК	783.4	298.5	38.1%	3.8	2019.01.25	2019.02.18	2019.03.18-нд олгов
2	LEND	ЛэндМН ББСБ	2,560.3	800.0	31.2%	1.0	2019.01.30	2019.02.22	2019.03.28-нд олгов
3	MBW	Монгол Базальт ХК	217.2	56.4	26.0%	1.0	2019.02.01	2019.03.25	2019.06.14-нд олгов
4	BTG	Баянтээг ХК	1,771.4	1,000.0	56.5%	3,958.7	2019.02.11	2019.03.04	2019.06.01-с
5	SUL	Жуулчин дюти фрий ХК	1,384.5	653.6	47.2%	10,000.0	2019.02.12	2019.04.10	2019.05.31-с
6	GOV	Говь ХК	17,764.2	5,304.8	29.9%	6.8	2019.02.13	2019.03.28	2019.04.25-с
7	ADU	Хөвсгөл алтан дуулга ХК	399.2	1,888.1	473.0%	120.0	2019.02.13	2019.04.01	2019.05.01-с
8	TCK	Талх чихэр ХК	1,975.9	204.7	10.4%	200.0	2019.02.14	2019.04.03	2019.07.01-с
9	MMX	Мах импекс ХК	778.6	456.1	58.6%	120.0	2019.02.14	2019.04.03	2019.10.01-с
10	BUK	УБ-БҮК ХК	566.4	131.5	23.2%	1.0	2019.02.14	2019.04.05	2019.05.01-с
11	ТАН	Тахь-ко ХК	799.1	128.5	16.1%	108.0	2019.02.15	2019.04.05	2019.04.24-нд олгов
12	BNG	Баянгол зочид буудал ХК	3,433.1	150.2	4.4%	355.0	2019.02.16	2019.04.05	2019.09.01-с
13	MNP	Монгол шуудан ХК	1,560.3	468.1	30.0%	4.7	2019.02.18	2019.04.05	2019.05.01-с
14	HRD	Хүрд ХК	751.1	74.4	9.9%	550.0	2019.02.18	2019.03.04	2019.06.01-ний дотор
15	MNDL	Мандал даатгал ХК	3,868.3	624.3	16.1%	100.0	2019.02.18	2019.04.10	2019.05.27-нд олгов
16	GTL	Гутал ХК	2,225.8	1,257.7	56.5%	777.0	2019.02.18	2019.03.13	2019.05.06-с
17	TEX	Техник импорт ХК	2,702.0	723.4	26.8%	500.0	2019.02.18	2019.03.11	2019.04.11-с
18	APU	АПУ ХК	57,851.7	48,952.4	84.6%	46.0	2019.02.19	2019.04.04	2019.05.20-нд олгов
19	AIC	Ард даатгал ХК	1,263.4	631.8	50.0%	25.3	2019.02.19	2019.03.15	2019.06.17-нд олгов
20	GHC	Ган хийц ХК	20.3	12.1	59.7%	50.0	2019.02.19	2019.03.22	2019.10.01-с
21	HUV	Хөвсгөл геологи ХК	107.4	14.4	13.4%	100.0	2019.02.19	2019.04.03	2019.04.29-с
22	HNS	Хөвсгөл хүнс ХК	11.3	2.6	23.4%	10.0	2019.02.19	2019.04.03	2019.05.15-с
23	TAL	Талын гал ХК	255.9	34.7	13.6%	50.0	2019.02.25	2019.03.26	2019.07.19-нд олгов
24	BRC	Барилга корпораци ХК	1,311.0	40.1	3.1%	985.0	2019.02.26	2019.03.18	2019.03.18
25	UBH	Улаанбаатар хивс ХК	235.6	48.6	20.6%	120.0	2019.02.26	2019.03.18	2019.05.31-ний дотор
26	DSS	Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК	11.5	11.4	99.2%	1.1	2019.03.01	2019.03.21	2019.07.02-с
27	ADL	Адуунчулуун ХК	547.1	409.7	74.9%	130.0	2019.03.11	2019.04.03	2019.07.26-нд олгов
28	TEE	Тээвэр дархан ХК	22.3	81.7	365.5%	500.0	2019.04.17	2019.03.27	2019.12.31-ний дотор
29	ERS	Монгол алт ХК	6.3	39.9	631.2%	150.0	2019.04.17	2019.03.27	2019.12.31-ний дотор
30	TTL	Таван толгой ХК	52,858.1	44,923.4	85.0%	853.0	2019.04.26	2019.04.01	2019.06.11-нд олгов
31	EER	Ариг гал ХК	449.3	109.4	24.3%	32.5	2019.04.26	2019.03.27	2019.09.30-ны дотор
32	HRM	Гермес центр ХК	481.3	447.7	93.0%	5.7	2019.08.15	2019.09.02	2019.09.12-с
33	SUU	Сүү ХК	5,706.4	1,143.4	20.0%	3.3	2019.09.09	2019.04.05	2019.09.09-с

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“Монос хүнс” ХК ТУЗ-ийн дэргэд стартеги, бизнес хөгжлийн хороо байгуулав

Энэ онд хөрөнгийн зах дээр IPO хийгээд буй “Монос хүнс” ХК /MSE:MFC/ ТУЗ-ийн дэргэдэх хороодыг байгуулсан талаар мэдээлэв.

Компанийн тухай хуулийн дагуу Аудитын хороо, Нэр дэвшүүлэх болон Цалин урамшууллын хороог нэгтгэсэн бол шинээр Стратеги, бизнес хөгжлийн хороог байгуулсан байна.

Тус хорооны даргаар Х.Анандыг, ТУЗ-ийн хараат бус гишүүнээр Б.Гантулга, Ч.Чинзориг нарыг нь томилжээ.

Эх сурвалж: MarketInfo.mn

Хорооны ээлжит 14-р хуралдаан боллоо

Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны ээлжит 14-р хуралдаан болж 14 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэв.

Хуралдаанаар “Эм Ай Ди Эй Си” ХХК-д хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, “Апекс капитал ҮЦК”-д гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, “Их агдир” ХХК-д банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олголоо. Зарим үнэт цаасны компанийн албан тушаалтныг томилох, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах, тусгай зөвшөөрөл нэмж олгох, сэргээх шийдвэр гаргаж, нэг үнэт цаасны компанийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгов.

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо



“АПУ” ХК-н зах зээлийн үнэлгээ 151.9 тэрбум төгрөгөөр буураад байна

Хамгийн өндөр зах зээлийн үнэлгээтэй “АПУ” /MSE:APU/ ХК-ийн хувьцааны ханш энэ 2019 он гарснаас хойш 22%-аар унаад байгаа. Энэхүү уналтаар ТОП-20 индексийн сагсанд байгаа болон I ангиллын компаниуд дундаа өндөр бууралттай хувьцааны нэг болж байгаа юм.

Тус компани оны эхэнд 687.2 тэрбум төгрөгийн зах зээлийн үнэлгээтэй байсан бол 2019.09.19-ний байдлаар 535.3 тэрбум төгрөг болж, үнэлгээ нь 151.9 тэрбум төгрөгөөр буурав.

2018 оны эхний хагас жилийн санхүүгийн үзүүлэлттэй харьцуулбал, борлуулалтын орлого нь нэмэгдсэн боловч цэвэр ашиг 4.5 тэрбум төгрөгөөр буурсан, хөрөнгийн зах зээлийн арилжааны идэвх суларч байгаа зэрэг шалтгаанууд энэхүү бууралтад гол нөлөө үзүүлжээ.

Мөн хувьцааны ханш уналттай байгаа ч зах зээлд анхлан орж буй хөрөнгө оруулагчдын дунд хувьцааны сонголт бага байгаа нь компанийн хувьцаа эзэмшигчдийн тоо нэмэгдүүлэх нөхцлийг бүрдүүлж байгааг хэлэх хэрэгтэй. Тодруулбал, оны эхнээс “АПУ” ХК-ын жижиг хувьцаа эзэмшигчдийн тоо 7.4%-аар өсөж 6,000-г даваад байгаа билээ.

Эх сурвалж: MarketInfo.mn

“Эрдэнэс-Тавантолгой” ХК олон улсын ISO стандартын гэрчилгээгээ авлаа

“Эрдэнэс-Тавантолгой” ХК нэгдсэн менежментийн тогтолцооны хүрээнд олон улсын ISO стандартуудыг нэвтрүүлж, баталгаажуулалтын гэрчилгээгээ энэ сарын 18-ны өдөр Парис хотноо “AFNOR” группийн Олон улсын бизнесийн Захирал Марьям Аугэрзу Ландесаас албан ёсоор хүлээн авлаа.

Тавантолгойн нүүрсний ордын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувьцааг гадаад, дотоодын хөрөнгийн биржээр арилжаалах бэлтгэл ажлын хүрээнд компанийн үйл ажиллагаанд 2017 оноос эхлэн ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоо, ISO 45001:2018 Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцоо, ISO 14001:2015 Байгаль орчны менежментийн тогтолцоог хэрэгжүүлэхээр үе шаттай ажлууд эхлүүлсэн юм.

Энэ хүрээнд “Эрдэнэс-Тавантолгой” ХК-аас Монголын Менежментийн Зөвлөхүүдийн Холбоо ТББ-аас зөвлөх үйлчилгээ авсны дараа олон улсын “AFNOR” группээс мэргэжлийн зөвлөхүүдтэй ажлын хэсэг гарган чанарын стандартыг баталгаажуулах урьдчилсан аудитыг хийлгэсэн юм.

Олон улсын ISO стандартуудыг компанийн үйл ажиллагаанд нэвтрүүлснээр үйлдвэрлэлийн чанарын тогтвортой байдлыг хангах, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй болон байгаль орчны үйл ажиллагааг хянах, удирдах, тасралтгүй сайжруулалтын арга хэмжээг авахад чиглэсэн менежментийн нэгдсэн тогтолцоотой болж байна.

Эх сурвалж: Montsame.mn

“Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн” ХК хөндий алтны төслийн өрөмдлөгийн 2-р шатны хөтөлбөрийг эхлүүлээ

“Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн” ХК (TSX:ERD | MSE:ERDN) нь Хөндий Алтны Төсөл дээр 2019 оны өрөмдлөгийн хөтөлбөрийн 2-р үе шатыг эхлүүлсэн байна.

Тус компани нь 2019 оны 2-р улиралд хийсэн өрөмдлөгийн үр дүнд 5.9г/т агууламж бүхий 112 метр гүнд өрөмдлөг хийж, Баян Хөндий ордын төв хэсэгт, дөт гүнд алтны өндөр агууламж бүхий бүс үргэлжилж буйг баталгаажуулсан бөгөөд энэхүү шинээр эхлүүлж буй өрөмдлөгийн хөтөлбөрөөр тус бүсийг үргэлжлүүлэн шалгана гэж мэдэгдлээ.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

“Ард кредит ББСБ” ХК олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийн тайлан ирүүлээ

Монголын хөрөнгийн биржид 2019 онд шинээр үнэт цаасаа бүртгүүлж, олон нийтээс 5.2 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн “Ард Кредит ББСБ” ХК нь татан төвлөрүүлсэн хөрөнгийг 2019 оны 9-р сарын 13-ны өдрийн байдлаар дараах байдлаар зарцуулсан тухай тайлан ирүүлсэн байна. Үүнд:

-Зээл олголт: 4.9 тэрбум төгрөг;

-Маркетингийн зардал: 205.5 сая төгрөг;

-Мэргэжлийн байгууллагуудын төлбөр, шимтгэл, хураамж: 276.5 сая төгрөг;

-Хэвлэл танилцуулганы зардал: 54.4 сая төгрөг.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

Алтны нөөц шаардлагатай хэмжээнд хүрэхгүй байх эрсдэлтэй

Монголбанк энэ оны эхний найман сард 9.6 тонн үнэт металл худалдан авсан нь өмнөх оны мөн үеэс 2.5 тонноор бага буюу 21%-аар буурчээ.

Өнгөрсөн онд Монголбанк 22 тонн алт худалдан авч, гадаад валютын нөөцийг 800 сая ам.доллараар нэмэгдүүлсэн. Харин энэ онд үнэт металлын худалдан авалт 20 тонн хүрэх эсэх нь эргэлзээтэй байна.

Дэлхийн худалдааны дайнтай холбоотой томоохон төв банкууд валютын нөөцөөс татгалзаж алт нөөцөлж эхэлсэн. Манай улс мөн энэ жишгийг дагаж байгаа ч Ашигт малтмалын нөөц ашигласны татвар 5 хувь болж хоёр дахин нэмэгдсэнээс гадна олборлолт буурсантай холбоотой алт тушаалт буурч байна. Энэ нь гадаад валютын нөөцийн дийлэнх хувийг бүрдүүлдэг алтны нөөц шаардлагатай хэмжээнд хүрэхгүй байх эрсдэл учруулж байгаа юм.

Өнгөрсөн 8-р сард Монголбанкны 1 грамм алт худалдаж авах дундаж үнэ 128 мянган төгрөг байлаа.

Эх сурвалж: Montsame.mn

Казахстан Хятадын нутгаар дамжуулан Азид нүүрс экспортолно

Казахстан улс нь Хятадын Лянжунган боомтоор дамжин Зүүн өмнөд Азийн зах зээлд нүүрс экспортолно. Энэ тухай тус улсын Үйлдвэр, дэд бүтцийн хөгжлийн сайд Роман Скляр мэдэгджээ. Казахстаны Ерөнхийлөгч Касым-Жомарта Токаев анх удаа БНХАУ-д хийсэн айлчлалын үеэр хоёр улс тохиролцсон байна. Казахстан нь жил бүр хоёр сая тонн нүүрсийг Хятадын нутгаар дамжуулан тээвэрлэж экспортлохоор урьдчилсан хэлэлцээр байгуулжээ.

Казахстаны хувьд далайд гарцгүй орон бөгөөд Оросын нутгаар дамжин нүүрсээ экспортолдог. Сүүлийн жил Казахстаны экспортын нүүрсийг Оросын нутгаар дамжуулан тээвэрлэх асуудалд хүндрэл үүсээд байгаа юм. Эргэн сануулахад, 2018 онд Казахстаны 14 сая тонн нүүрсийг Алс Дорнодын боомтоор экспортлох транзит тээврийн саналаас Оросууд татгалзсан удаатай. Оросын нүүрсний салбарын өрсөлдөх чадварт сөргөөр нөлөөнө гэж үзсэн.

Өнөөгийн байдлаар БАМ төмөр замын шинэчлэлтэй холбоотойгоор Казахстаны нүүрсний транзит тээврийг Оросын талаас хязгаарлаж байгаа юм. Тэгвэл өнгөрсөн зургадугаар сараас Оросын Засгийн газрын Украин руу нүүрс, газрын тос экспортлох хоригтой холбоотойгоор Казахстан болон Киргизийн нүүрсний Оросын нутгаар дамжих транзит тээвэр 60 орчим хувиар буураад байна. Энэ асуудлаар өнөөг хүртэл гурван улс тохиролцоонд хүрч чадаагүй байгаа юм. Оны эхний хагас жилийн байдлаар, Казахстан улс нийт 11 сая гаруй тонн нүүрс экспортолжээ.

Эх сурвалж: MongolianMiningJournal.com

БУСАД МЭДЭЭ

Бодлогын хүүг 11 хувьд хадгаллаа

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны ээлжит хурлаар Бодлогын хүүг 11 хувьд хадгалах шийдвэр гаргалаа.

Уг шийдвэр нь инфляцыг зорилтот түвшиний орчимд тогтворжуулж, эдийн засгийн өсөлтийг дэмжих, макро эдийн засгийн болон санхүүгийн дунд хугацааны тогтвортой байдлыг хадгалах зорилттой нийцэж байгааг Монголбанкны тэргүүн дэд Ерөнхийлөгч О.Эрдэмбилэг онцлов.

Тэрбээр: "Инфляц өнгөрсөн 8-р сард улсын хэмжээнд 8.9 хувь байлаа. Мах, хүнсний ногоо, их дээд сургуулиудын сургалтын төлбөр болон бусад төрийн зохицуулалттай бүтээгдэхүүний үнэ сүүлийн саруудад өсөж, нийлүүлэлтийн шалтгаантай инфляцыг нэмэгдүүллээ. Эрэлтийн шалтгаантай суурь инфляц харьцангуй тогтвортой байна. Инфляцад нөлөөлж буй хүчин зүйлс, эдийн засгийн идэвхжлийг харгалзан үзэхэд инфляц зорилтот түвшин орчимд тогтворжих төлөв хадгалагдаж байна.

Энэ оны эхний хагас жилд уул уурхайн олборлолтын хэмжээн хүлээлтээс давж, бизнесийн зээл, өрхийн хэрэглээ, хөрөнгө оруулалт, төсвийн зардал нэмэгдсэнээр эдийн засгийн өсөлт өндөр түвшинд хадгалагдлаа" гэв.

Өмнөх онуудтай харьцуулахад том гүрнүүдийн худалдааны сөргөлдөөн улам гүнзгийрч, гадаад орчны тодорхой бус байдал нэмэгдэн, цаашид гадаад эрэлт, түүхий эдийн үнэ, гадаадын шууд хөрөнгө оруулалтаар дамжин дотоод эдийн засагт сөргөөр нөлөөлөх эрсдэл байна.

Иймд дотоод, гадаад тэнцвэрийг хадгалахад чиглэсэн макро эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэх, бүх секторын түвшинд санхүүгийн нөөц хуримтлуулж, эрсдэл даах чадварыг бэхжүүлэх шаардлагатай байгааг Монголбанкнаас онцоллоо.

Эх сурвалж: Montsame.mn

Дэлхийн банк Монгол Улсад 100 сая ам.долларын санхүүжилт олгоно

Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Дэлхийн банкны Монгол дахь суурин төлөөлөгч Андрей Михнев нар "Эдийн засгийн удирдлагыг дэмжих хөтөлбөр"-ийн хоёр дахь шатны 100 сая ам.долларын санхүүжилтийн гэрээнд гарын үсэг зурлаа.

Тус санхүүжилтийг Монгол Улсын Засгийн газраас ОУВС-тай хамтран хэрэгжүүлж буй "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-ийн хүрээнд олгож байгаа юм. Хөтөлбөрийн эхний санхүүжилт болох 120 сая ам.долларыг 2017 оны 12-р сард олгосон. Харин хоёр дахь шатны 100 сая ам.долларыг Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциаци, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хамтран олгож байна.

Уг санхүүжилт нь төсвийн хөрөнгө оруулалттай төслүүдийн зардлыг бууруулж, үр ашгийг нэмэх, орон сууцны ипотекийн хөтөлбөрийг сайжруулах, нийгмийн хамгааллын тогтолцоог бэхжүүлэх, бизнес худалдааны орчинг сайжруулах, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилтийг хангахад чиглэнэ.

Эх сурвалж: Montsame.mn

мэдэгдэл

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.